

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗАР

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/126/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймгийн Сайншанд сум 2019 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: <a href="mailto:ariunaa.ch@audit.gov.mn">ariunaa.ch@audit.gov.mn</a> Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг Утас: 70523020 Цахим хаяг: Аудитор: Ц.Ганцэцэг Утас: 99060263 Цахим хаяг: <a href="mailto:shilenbalanseaudit@gmail.com">shilenbalanseaudit@gmail.com</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал.....	11
1.1 Зардлын данстай холбоотой асуудал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18

## Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Эвб сафт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗРЫН  
ДАРГА Ж.НАРАНБОЛД  
ТАНАА

2020.02.28 № 1-6/143  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ж.Наранболдод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй үр нөлөөтэй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25 -ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Ц.Ганцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж, үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангахуйц бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжих хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийг хангах үйлдвэрлэл үйлчилгээг нэвтрүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлж иргэдийг экологийн цэвэр, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, мал эрүүлжүүлэх замаар хүн амын хүнсний баталгаат байдлыг хангаж төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэхэд оршино гэсэн эрхэм зорилго дор үйл ажиллагааны чиглэл зорилго тодорхойлон ажиллажээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, удмын сан эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах
- Хүнсний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, усжуулах арга хэмжээг өргөжүүлэн, уст цэгийн ашиглалт, эзэмшилтийг сайжруулах
- Мал сүргийн бүтэц, сүргийн чанарыг сайжруулж, удмын санг хамгаалахын зэрэгцээ мал сүргийг байгалийн гамшгаас сэргийлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Мал, амьтны халдварт, паразиттай өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээний үр дүнг дээшлүүлж, өвчний тархалт гаралтыг тогтвортой бууруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй. Байгууллагын бүтцэд томоохон өөрчлөлт орсон. Үүнд: Хүнс, хөдөө аж ахуйн бүтцэд байсан Мал эмнэлгийн албыг салгаж Мал эмнэлгийн газар болгон тусгаарласан байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хүнс, хөдөө аж ахуйн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Dynamic” программ ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим, сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 252,463.4 мянган төгрөгөөс тооцон 5,049.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,049.3 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 705,649.5 мянган төгрөгөөр буюу 70.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		4,200.0	4,200.0
Авлага	1,481.1	4,956.8	3,475.7
Урьдчилгаа			
Бараа материал	254,388.8	78,646.8	-175,742.0
Үндсэн хөрөнгө	744,440.8	206,857.6	-537,583.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,000,310.7</b>	<b>294,661.2</b>	<b>-705,649.5</b>
Өр төлбөр	317.2		-317.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	999,993.5	294,661.2	705,332.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,000,310.7</b>	<b>294,661.2</b>	<b>-705,649.5</b>

Мөнгөн хөрөнгө дансанд тайлант онд байгуулсан ахмадын сангийн үлдэгдэл 4200.0 мянган төгрөг тусгагдсан байна.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь өнгөрсөн онд үүссэн 1,481.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан боловч, шинээр 4,956.8 мянган төгрөгийн авлага үүссэн, энэ нь ус, дулааны зардалд 1271.8 мянган төгрөг, татварт 97.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн, тайлант онд орон нутгийн төсвөөс худаг гаргасны хяналтын зардлын 648.0 мянган төгрөгийг төвлөрүүлж дараа онд хяналт тавих зардлыг буцаан авахаар тооцож байгууллагаас авах авлагаар, оны эцэст туслах аж ахуйгаас заазлагдсан малыг ажилчдад олгож 2940.0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлагаар тус тус тусгаснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь Төрийн өмчийн тогтоолоор Мал эмнэлэгт 486.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3,071.8 мянган төгрөгийн аж ахуйн материал, 880.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 178,223.0 мянган төгрөгийн эм боох материал, нийт 182,662.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн, тайлант хугацаанд 1,580.2 мянган төгрөгийн бичиг хэргийн, 15413.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,249.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 8805.1 мянган төгрөгийн шатахуун, тослох материал, 1350.0 мянган төгрөгийн мал худалдан авч 26,708.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд байгаа бараа материал ашиглалтад байна.

Үндсэн хөрөнгө буурсан нь тайлант онд 1,500.0 мянган төгрөгийн Dynamic санхүүгийн программ, 10,298.0 мянган төгрөгийн компьютер, багаж, тоног төхөөрөмж худалдан авч, ХХААХҮЯ-аас 689.8 мянган төгрөгийн үнэтэй малын пүү үнэ төлбөргүй шилжүүлэн орлогод авсан, 2019 оны 01 дүгээр сарын 01-ээс Мал эмнэлэг бүтцээс гарч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 513 дугаар тогтоол, 2019 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/4247 тоот албан бичгийг үндэслэн 232,336.9 мянган төгрөгийн барилга байгууламж, 88,948.8 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 157,850.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 20,713.1 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 160,885.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 97,248.0 мянган төгрөгийн газар, нийт

757,316.9 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө /хуримтлагдсан элэгдэл-261458.0/ үнэ төлбөргүй шилжүүлснээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өнгөрсөн оны ХХОАТ-ын өглөгийг тайлант онд барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 294,661.2 мянган төгрөг болж 705,332.3 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолыг хэрэгжиж 495,858.9 мянган төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хөрөнгө, 182,662.4 мянган төгрөгийн бараа материал, дахин үнэлгээний зөрүүгээс 188,847.7 мянган төгрөг шилжүүлсэн болон тухай жилийн үр дүн 26,811.0 мянган төгрөг нэмэгдсэн зэргээс шалтгаалжээ

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант онд 500,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 500,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	500.0	500.0		100
<b>Нийт дүн</b>	500.0	500.0		

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 257,871.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 257,871.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 257,871.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 500.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 252,463.4 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь байр ашиглалтын зардлаас 17.7, хангамжийн материал 70.3, томилолтын зардал 99.3, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрөөс 4,865.0, бусад урсгал зардлаас 355.9 мянган төгрөг нийт 5,408.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. /Голлох хэмнэлт нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ болон бүтэц орон тоо хэмнэлттэй ажилласантай холбоотой цалин, татвар, шимтгэлийн зардлын үлдэгдэлтэй холбоотой/

**Нэмэлт төсөв:** Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 84,483.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,796.9 мянган төгрөг, нийт 104,280.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс малын төлөв байдлыг үнэлэхэд 11,593.8 мянган төгрөг, үлийн цагаан огтоотой тэмцэхэд 48,000.0 мянга, Малын ангилалт хийхэд 24,448.7 мянга, худгийн хяналтын зардалд 4,279.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоо 6,317.4 мянган төгрөгийг Сангийн сайдын тушаалаар үйл ажиллагаандаа зарцуулсан. нийт 99,432.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 648,0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж, нийт 2 горим сорил хэрэгжүүллээ.

### **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй болно. Энэ нь аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад түүвэрт хамруулан шалгаж амжаагүй дээрх асуудлыг 2020 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар зөрчилгүй санал дүгнэлттэй, акт, зөвлөмж өгөгдөөгүй байна

### **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

#### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Засвартай томилолтын хуудсыг үндэслэн 146.8 мянган төгрөгийг олгосон зөрчил нь тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 “*Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*” заалтыг зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтын бүрдэлтэд тавих хяналтыг сайжруулж, холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

## **3.2 Балансын данстай холбоотой**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Санхүүгийн тайланд 4,956.8 мянган төгрөгийн авлага тусгасан байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байхаас гадна УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* заалтыг зөрчсөн байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Авлага барагдахгүй байх

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* заалтыг мөрдөж ажиллах.

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

## **3.3 Балансын данстай холбоотой**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Бараа материал, үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн. Тухайлбал 975,0 мянган төгрөгийн камер, 855,0 мянган төгрөгийн 2 ширхэг микроскоп, 184,5 мянган төгрөгийн зурагт, 2578,3 мянган төгрөгийн 5 ширхэг электрон жин, 12205,6 мянган төгрөгийн 5 ширхэг ноос преслэгч зэрэг үндсэн хөрөнгүүдийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь үнэн зөв байдал, ангилал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал 4,16 "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Хөрөнгийн эдийн засгийн өгөөж, үйлчилгээний чадамж дутуу үнэлэгдэж хөрөнгө ашиглагдаж, шамшигдах эрсдэлтэй.

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгийг бараа материал данснаас үндсэн хөрөнгийн холбогдох дансанд шилжүүлэн бүртгэх.

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>255,869,875.78</b>	<b>87,803,621.85</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	4,200,000.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	4,200,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	4,200,000.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	4,200,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,481,105.00	4,956,846.40
33300	Татаас, санхүүжилтийн авлага	441,200.00	648,020.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,039,905.00	4,308,826.40
3351	Байгууллагаас авах авлага	1,019,905.00	1,368,826.40
3352	Хувь хүмүүсээс авах авлага	20,000.00	2,940,000.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	222,360,169.07	48,368,670.63
35110	Тусгай зориулалттай материал	44,137,144.56	48,368,670.63
35130	Эм боох материал	178,223,024.51	00.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	24,649,601.71	24,278,104.82
35410	Бичиг хэргийн материал	2,354,234.00	1,417,334.00
35420	Аж ахуйн материал	20,028,547.71	22,277,770.82
35430	Сэлбэг хэрэгсэл	2,189,060.00	570,300.00
35440	Түлш, шатах тослох материал	77,760.00	12,700.00
35600	Мал амьтад	7,379,000.00	6,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>744,440,824.69</b>	<b>206,857,591.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	744,440,824.69	206,857,591.63
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	580,240,824.69	139,340,591.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	360,840,551.00	128,503,615.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-12,842,488.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	135,248,772.52	46,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-97,915,439.24	-46,300,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,408,963.74	47,211,723.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-58,916,039.03	-30,592,200.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,718,052.00	14,004,967.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,093,882.49	-7,162,225.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	170,610,377.71	9,725,374.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-140,660,531.52	-9,508,174.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	164,200,000.00	67,516,999.92
39301	Програм хангамж	4,408,145.00	5,908,145.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-208,145.00	-1,143,145.08
39303	Бусад биет бус хөрөнгө	160,000,000.00	62,752,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,000,310,700.47</b>	<b>294,661,213.48</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>317,173.20</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	317,173.20	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	317,173.20	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	317,173.20	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>999,993,527.27</b>	<b>294,661,213.48</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	999,993,527.27	294,661,213.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	829,485,493.11	829,485,493.11
51101	Өмч: - төрийн	829,485,493.11	829,485,493.11
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-102,822,573.37	-619,307,144.60
51210	Өмнөх үеийн үр дүн	-102,822,573.37	86,025,169.20
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-705,332,313.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	273,330,607.53	84,482,864.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,000,310,700.47</b>	<b>294,661,213.48</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,464,505,212.60</b>	<b>372,512,122.07</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	00.00	00.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,266,219,971.60</b>	<b>10,800,919.07</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,266,219,971.60	10,800,919.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,266,219,971.60	2,940,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,377,924.00	00.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,940,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,263,842,047.60	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,198,285,241.00</b>	<b>361,711,203.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	265,394,100.00	257,871,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265,394,100.00	257,871,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	932,891,141.00	103,839,403.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,655,290.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	788,175,851.00	84,042,520.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00	14,796,883.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,337,607,753.74</b>	<b>399,323,132.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,337,607,753.74</b>	<b>399,323,132.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,335,916,898.24	372,240,409.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	203,013,860.70	143,553,199.20
210101	Үндсэн цалин	171,921,855.70	143,553,199.20
210102	Нэмэгдэл	21,190,405.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,901,600.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,442,439.00	18,697,003.68
210201	Тэтгэврийн даатгал	11,653,584.30	18,697,003.68
210202	Тэтгэмжийн даатгал	12,788,854.70	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,923,570.00	10,321,406.60
210301	Гэрэл, цахилгаан	2,977,690.00	1,666,939.00
210302	Түлш, халаалт	16,484,522.00	8,039,523.60
210303	Цэвэр, бохир ус	461,358.00	614,944.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,164,910.40	12,795,028.00
210401	Бичиг хэрэг	1,241,418.40	1,644,600.00
210402	Тээвэр, шатахуун	9,440,100.00	8,870,123.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,589,674.00	881,498.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	213,800.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	276,878.00	375,807.00
210408	Бараа материал акталсны зардал	403,040.00	879,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,080,028,407.66	2,050,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,079,708,557.66	00.00
210502	Хоол, хүнс	89,000.00	1,850,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	230,850.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,744,960.00	5,976,290.51
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,200.00	81,000.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	2,685,760.00	5,895,290.51
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	8,986,400.00	8,101,300.00

210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	8,986,400.00	8,101,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>936,529,622.00</b>	<b>113,693,281.18</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	934,764,478.00	112,027,053.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,188,000.00	1,187,948.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,100.00	70,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	68,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	81,044.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,082,728.48</b>	<b>57,052,900.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,045,222.00	1,340,754.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,037,506.48	54,212,146.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,690,855.50</b>	<b>27,082,722.62</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,320,653.00</b>	<b>21,174,308.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,320,653.00	336,794.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,900,259.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,937,255.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>370,202.50</b>	<b>5,908,414.62</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	370,202.50	5,908,414.62
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>126,897,458.86</b>	<b>-26,811,010.53</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>96,408,968.68</b>	<b>678,521,303.26</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	87,246,175.68	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	9,162,793.00	00.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал /Үндсэн хөрөнгө/		495,858,907.95
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал /Бараа материал/		182,662,395.31
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-96,408,968.68</b>	<b>-678,521,303.26</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>30,488,490.18</b>	<b>-705,332,313.79</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,200,731,141.00</b>	<b>362,652,403.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,445,900.00</b>	<b>500,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,445,900.00</b>	<b>500,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,445,900.00	500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,445,900.00	500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,198,285,241.00</b>	<b>362,152,403.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>265,394,100.00</b>	<b>257,871,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265,394,100.00	257,871,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>932,891,141.00</b>	<b>104,280,603.00</b>
131103	ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,655,290.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	783,503,650.00	84,483,720.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,732,201.00	14,796,883.00

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,200,811,141.00</b>	<b>346,654,403.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,200,811,141.00</b>	<b>346,654,403.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,198,908,112.50</b>	<b>319,103,660.38</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	203,555,202.70	143,553,199.20
210101	Үндсэн цалин	172,463,197.70	110,795,099.20
210102	Нэмэгдэл	21,190,405.00	26,221,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,901,600.00	6,536,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,357,547.00	17,944,100.00
210201	Тэтгэврийн даатгал	16,212,147.00	12,202,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,036,300.00	1,435,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,629,100.00	1,148,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	407,300.00	287,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,072,700.00	2,871,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,825,475.00	11,338,908.00
210301	Гэрэл, цахилгаан	2,977,690.00	1,533,108.00
210302	Түлш, халаалт	15,849,029.00	8,951,300.00
210303	Цэвэр, бохир ус	998,756.00	854,500.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,813,910.80	6,350,230.00
210401	Бичиг хэрэг	1,187,300.00	955,300.00
210402	Тээвэр, шатахуун	8,284,700.00	3,814,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,612,174.00	923,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	213,800.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	515,936.80	513,130.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	490,200.00	1,082,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	259,350.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	230,850.00	1,082,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,536,800.00	7,465,975.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	243,000.00	1,025,000.00
210602	Тавилга	00.00	1,650,880.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	2,293,800.00	4,790,095.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	8,737,400.00	8,295,300.00
210701	Гадаад албан томилот	00.00	00.00
210702	Дотоод албан томилот	8,737,400.00	8,295,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	926,300,355.00	119,563,875.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	924,524,211.00	117,897,647.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,188,000.00	1,187,948.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,100.00	70,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	68,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	81,044.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,291,222.00	3,509,273.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,291,222.00	2,009,273.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,903,028.50</b>	<b>27,550,742.62</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,091,626.00	20,994,308.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,091,626.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,900,259.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,094,049.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	811,402.50	6,556,434.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	811,402.50	6,556,434.62

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>-80,000.00</b>	<b>15,998,000.00</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,000,000.00	11,798,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,000,000.00	11,798,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,000,000.00	11,798,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,000,000.00	11,798,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>-1,000,000.00</b>	<b>-11,798,000.00</b>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>00.00</b>	<b>00.00</b>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>00.00</b>	<b>00.00</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-1,080,000.00	4,200,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,080,000.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	4,200,000.00

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	669,485,493.11	3,206,988.96	-133,313,123.55	539,379,358.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	669,485,493.11	3,206,988.96	-133,313,123.55	539,379,358.52
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,328,399.18	1,328,399.18
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	829,485,493.11	273,330,607.53	-102,822,573.37	999,993,527.27
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	829,485,493.11	273,330,607.53	-102,822,573.37	999,993,527.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	188,847,742.57	188,847,742.57
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	829,485,493.11	273,330,607.53	86,025,169.20	1,188,841,269.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-188,847,742.57	00.00	-188,847,742.57
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-705,332,313.79	-705,332,313.79
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	829,485,493.11	84,482,864.97	-619,307,144.60	294,661,213.48

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	267,394,200.00	268,663,451.00	257,871,800.00	252,463,385.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	267,394,200.00	268,663,451.00	257,871,800.00	252,463,385.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	266,294,200.00	267,571,826.00	236,521,600.00	231,469,077.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,633,700.00	203,555,200.00	143,553,200.00	143,553,199.20
210101	Үндсэн цалин	163,635,900.00	172,463,191.00	110,895,100.00	110,795,099.20
210102	Нэмэгдэл	29,681,300.00	21,190,409.00	26,121,600.00	26,221,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,316,500.00	9,901,600.00	6,536,500.00	6,536,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,461,400.00	24,357,547.00	17,944,100.00	17,944,100.00
210201	Тэтгэврийн даатгал	16,316,000.00	16,212,147.00	12,202,000.00	12,202,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,036,300.00	2,036,300.00	1,435,500.00	1,435,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,629,100.00	1,629,100.00	1,148,400.00	1,148,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	407,300.00	407,300.00	287,100.00	287,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,072,700.00	4,072,700.00	2,871,100.00	2,871,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,789,700.00	19,789,700.00	11,356,600.00	11,338,908.00
210301	Гэрэл, цахилгаан	2,292,800.00	2,941,915.00	1,550,800.00	1,533,108.00
210302	Түлш, халаалт	16,642,400.00	15,849,029.00	8,951,300.00	8,951,300.00
210303	Цэвэр, бохир ус	854,500.00	998,756.00	854,500.00	854,500.00
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,856,500.00	6,855,510.00	6,420,500.00	6,350,230.00
210401	Бичиг хэрэг	1,134,300.00	1,187,300.00	955,300.00	955,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,814,400.00	3,326,300.00	3,814,400.00	3,814,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,180,400.00	1,612,174.00	923,400.00	923,400.00
210404	Ном, хэвлэл	00.00		00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	213,800.00	213,800.00	213,800.00	144,000.00

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	513,600.00	515,936.00	513,600.00	513,130.00
2105	Нормативт зардал	490,200.00	490,200.00	232,800.00	232,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	257,400.00	259,350.00	00.00	00.00
210502	Хоол, хүнс	232,800.00	00.00	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	230,850.00	232,800.00	232,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,536,800.00	2,536,800.00	13,296,800.00	13,296,575.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	243,000.00	243,000.00	10,243,000.00	10,243,000.00
210604	Урсгал засвар	2,293,800.00	2,293,800.00	3,053,800.00	3,053,575.00
2107	Томилолт, зочны зардал	3,893,400.00	4,973,400.00	6,529,400.00	6,430,100.00
210702	Дотоод албан томилолт	3,893,400.00	4,973,400.00	6,529,400.00	6,430,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,741,200.00	3,722,244.00	33,678,900.00	28,813,892.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,946,100.00	1,946,100.00	30,383,800.00	25,647,664.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,188,000.00	1,188,000.00	1,188,000.00	1,187,948.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,100.00	146,100.00	146,100.00	70,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00	121,000.00	68,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00		1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	81,044.00	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	891300.00	1291222.00	3509300.00	3509273.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	891,300.00	00.00	1,500,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,291,222.00	2,009,300.00	2,009,273.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	21350200.00	20994308.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	21,350,200.00	20,994,308.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,100,000.00	1,091,626.00	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг	00.00	00.00	18,250,200.00	17,900,259.00

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	удаагийн мөнгөн тэтгэмж				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	3,100,000.00	3,094,049.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>267,394,200.00</b>	<b>267,583,452.5</b>	<b>257,871,800.0</b>	<b>252,463,385.38</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>267,394,200.00</b>	<b>265,137,552.50</b>	<b>257,871,800.00</b>	<b>251,963,385.38</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	267,394,200.00	265,137,552.50	257,871,800.00	251,963,385.38
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>500,000.00</b>
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,100.00	2,445,900.00	00.00	500,000.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>24.00</b>	<b>24.00</b>
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	16.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	07.00	08.00

**4.6 Нэмэлт санхүүжилтын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>99,432,583.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>99,432,583.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>99,432,583.00</b>
2105	Нормативт зардал	850,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,467,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,080,000.00
210602	Тавилга	1,650,880.00
210604	Урсгал засвар	1,736,520.00
2107	Томилолт, зочны зардал	1,865,200.00
210702	Дотоод албан томилолт	1,865,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,249,983.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,249,983.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>100,080,603.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,080,603.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,483,720.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,596,883.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(4,200,000.00)